



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДУУРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрээс гадна байрлаж, "Худалдааны газар, түүний үйлчилгээ MNS5021:2007" стандартын шаардлага ханган үйл ажиллагаа явуулж буй хавсралтад заасан нэр бүхийн байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тул хугацааг сунгаж олгохыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.
2. Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох худалдаа үйлчилгээний байгууллагын нэрийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд болон тусгай зөвшөөрөл авсан худалдаа үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЭРДЭНЭБАЯР

С.ЭРДЭНЭБАЯР

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2022 оны 06 дугаар сарын 29...ны өдрийн
2022 дугаар захирамжийн хавсралт



ТАМХИ ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Д/д	Худалдаа үйлчилгээний байгууллагын нэр	Захирлын нэр	Хаяг байршил	Харилцах утас	Дууссан огноо	Олгох огноо
1	Аз хур баялаг ХХК	Н.Энхсайхан	2-р хороо Бор -үзүүр гэр хорооллын 1-1 тоот	95862058	2022.06.07	2022.06.07 (3 жил)



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 25-өдөр

Дугаар А/141

Улаанбаатар хот

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрээс гадна байрлаж, "Худалдааны газар, түүний үйлчилгээ MNS5021:2007" стандартын шаардлага ханган үйл ажиллагаа явуулж буй хавсралтад заасан нэр бүхий байгууллагад тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.
2. Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох худалдаа үйлчилгээний байгууллагын нэрийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд болон тусгай зөвшөөрөл авсан худалдаа үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ЭРДЭНЭБАЯР



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ТАМХИ ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Д/д	Худалдаа үйлчилгээний байгууллагын нэр	Захирлын нэр	Хаяг байршил	Харилцах утас	Олгох огноо
1	Сэтгэлийн гэгээ ХХК-ний Буянарвижих-2	Н.Оюунчимэг	1-р хороо Үнэгтэй 1а-1тоот	99651647	2022.08.29- 2025.08.29. (3 жил)



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДУУРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар A/62

Улаанбаатар хот

Тамхи худалдах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 5.5.14 дэх заалт, 8.2 дугаар зүйлийн 8.2, 11.6 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Худалдааны газрын стандартын шаардлага хангасан ерөнхий боловсролын сургуулийн 500 метрийн тойргоос гадна байрлах үйл ажиллагаа явуулж буй хавсралтад заасан нэр бүхий байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан тул хугацааг сунгаж олгохыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох худалдаа үйлчилгээний байгууллагын нэrsийг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд болон зөвшөөрөл авсан худалдаа үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СУХБОЛД



Нийслэлийн Багахангай дуургийн Засаг даргын
2023 оны 03 сарын 08 –ны өдрийн 11:00
дугаар Захирамжийн хавсралт

ТАМХИ ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, ИРГЭН

Д/д	Худалдаа үйлчилгээний байгууллага, иргэний нэр	Захирлын нэр	Хаяг байршил	Утас
1	Авдрын гол овоо ХХК	Б.Мөнхтүвшин	2-р хороо, Өртөөний хэсэг 1020 тоот	80112802
2	Хангай булаг ХХК	Д.Алтанчимэг	2-р хороо, Бор үзүүр 2-1 тоот	88075476
3	Иргэн	Д.Ганболд	1-р хороо 6 дугаар байрны 48 тоот	99786917
4	Иргэн	Г.Алтанцэцэг	1-р хороо 5 дугаар байрны 39 тоот	80150868



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДУУРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 8/122

Улаанбаатар хот

Тамхи худалдах зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 5.5.14 дэх заалт, 8.2 дугаар зүйлийн 8.2.11.6 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Худалдааны газрын стандартын шаардлага хангасан ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрнаас 500 метрийн тойргоос гадна байрлан үйл ажиллагаа явуулж буй хавсралтад заасан нэр бүхий байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинээр олгохыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох худалдаа үйлчилгээний байгууллагын нэрийг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд болон зөвшөөрөл авсан худалдаа үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 06.. дүгээр сарын 16..... ны өдрийн
0/02 дугаар захирамжийн хавсралт



ТАМХИ ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭГ ОЛГОХ ИРГЭН

Д/д	Худалдаа үйлчилгээний байгууллага, иргэний нэр	Захирлын нэр	Хаяг байршил	Харилцах утас
1.	Иргэн	Ц.Туулцэцэг	2-р хороо Бор үзүүр гэр хороолол 3-18 тоот	99332786



**БАГАХАНГАЙ ДУУРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 5159

Улаанбаатар хот

**Тамхи худалдах зөвшөөрөл
олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 5.5.14 дэх заалт, 8.2 дугаар зүйлийн 8.2.11.6 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Худалдааны газрын стандартын шаардлага хангасан еренхий боловсролын сургуулийн хичээлийн байрнаас 500 метрийн тойргоос гадна байрлан үйл ажиллагаа явуулж буй хавсралтад заасан нэр бүхий байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинээр олгохыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох худалдаа үйлчилгээний байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилт, зөвшөөрөл авсан худалдаа үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 07 сарын 01-ны өдрийн 11 дугаар
захирамжийн хавсралт

ТАМХИ ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ ИРГЭН

Д/д	Худалдаа үйлчилгээний байгууллага, иргэний нэр	Захирлын нэр	Хаяг байршил	Харилцах утас
1.	Иргэн	Г.Гандерөө	1-р хороо Үйлдвэрийн бүсэд	88075467



БАГАХАНГАЙ ДУУРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар A/198

Улаанбаатар хот

Засаг даргын дэргэдэх худалдаа,
үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн,
дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн үйл ажиллагаанд төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийж, хяналт тавих зорилгоор Засаг даргын дэргэдэх Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн ажиллах бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн байгуулсугай.

2. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Зөвлөл нь үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зөвлөлийн гишүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, дүүргийн хэмжээнд худалдаа үйлчилгээний цэг салбаруудын үйл ажиллагаанд зохицуулалт хийн, хяналт тавьж, зохион байгуулсан ажлыг тайлagnаж ажиллахыг Засаг даргын дэргэдэх Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл (Г.Дагвадорж)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн A/16 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дуургийн Засаг даргын
2024 оны 1..дүгээр сарын 1-ны өдрийн 1..дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**"ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛ"-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга:

Дүүргийн менежер

Дэд дарга:

Засаг даргын Тамгын газрын

Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

Гишүүн:

Засаг даргын Тамгын газрын Санхүү,

Төрийн сангийн хэлтсийн дарга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн

Эрх зүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хөрөнгө
орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн

Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн

Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Дүүргийн Цагдаагийн хэлтсийн Хэв журмын ажил
хариуцсан Ахлах байцаагч

Дүүргийн Татварын хэлтсийн дарга

Дүүргийн Газар зохион байгуулалтын
албаны дарга

1 дүгээр хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

Дүүргийн Ахмадын хорооны дарга

Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн Худалдаа үйлчилгээ,

үйлдвэрлэл хариуцсан Ахлах

мэргэжилтэн

Нарийн бичиг:

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны дүгээр сарын..-ны өдрийн дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ "ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ"-ИЙН ШИНЭЧИЛСЭН ДҮРЭМ

НЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Багахангай дүүргийн Засаг даргын дэргэдэх "Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл" нь /цаашид Зохицуулах зөвлөл гэнэ/ дүүргийн хэмжээнд худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, тэдгээрт тавигдах шаардлагыг тодорхойлох, бүртгэлжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нутгийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийх, Засаг даргын зүгээс хууль тогтоомжид заасан худалдаа, үйлчилгээтэй холбоотой бүрэн эрхээс хэрэгжүүлэхэд зөвлөх, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нэгдсэн бодлого чиглэлээр хангахад оршино.

1.2. Засаг даргын дэргэдэх "Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл" нь холбогдох хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мэрдлэг болгон ажиллана.

ХОЁР ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Зохицуулах зөвлөл нь дүүргийн Засаг даргын дэргэд орон тооны бус байдлаар ажиллана.

2.2. Зохицуулах зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.3. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг дүүргийн Засаг дарга батална.

2.4. Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөлийн шийдвэр нь хуралдааны тэмдэглэл байх ба түүнийг үндэслэн гарах Засаг даргын захирамж байна.

2.5. Зохицуулах зөвлөлийн дарга нь дүүргийн менежер, дэд дарга Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга, нарийн бичгийн дарга нь тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

2.6. Зохицуулах зөвлөлийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, хуралдаан даргалах, гишүүддээ ажил үүргийг хуваарилан хариуцуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, ажлынх нь үр дүнг тооцож ажиллана.

2.7. Зохицуулах зөвлөл нь энэхүү дүрмийн хүрээнд хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлаар санал гарган, дүүргийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

2.8. Энэ журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд авсан арга хэмжээний талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад хагас, бүтэн жилээр тайлагнаж, өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлэх.

2.9. Зөвлөлийн хурал шаардлагатай тохиолдолд хуралдана. Шаардлагатай тохиолдолд шуурхай хуралдааныг зөвлөлийн дарга болон гишүүдийн олонхын саналаар зарлан хуралдуулна. Зөвлөлийн даргын эзгүйд дэд дарга Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга хуралдааныг даргална.

2.10. Зохицуулах зөвлөлийн гишүүдийн 50-аас дээш хувийн ирц бүрдсэн нөхцөлд хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.11. Зохицуулах зөвлөлийн хурлын тэмдэглэлд Зохицуулах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Зөвлөлийн даргын

эзгүйд дэд дарга Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга гарын үсэг зурна.

ГУРАВ. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.1.Зохицуулах зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй байна.

3.1.2.Зохицуулах зөвлөл нь дүүргийн худалдаа, үйлчилгээний салбарын бодлого, хэтийн зорилго, журмыг хэлэлцэх, тулгамдсан буй асуудлын талаар санал боловсруулан холбогдох бусад байгууллагуудад асуудлыг тавьж шийдвэр гаргуулах

3.1.3.Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний газруудын нэгдсэн мэдээллийн санг бий болгож, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.1.4.Худалдаа, үйлчилгээний цэг салбар, нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах,

3.1.5.Цагийн хуваарь, стандартын шаардлага заавар, журам зөрчсөн үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээг зогсоох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар холбогдох байгууллагуудад санал тавьж шийдвэрлүүлэх.

3.1.6.Захиргааны журмаар хураагдсан эд зүйл болон бараа бүтээгдэхүүнийг улсын орлого болгох, устгах, худалдан борлуулах асуудлыг хэлэлцэн, дүүргийн Засаг даргын шийдвэр гаргуулж, биелэлтийг ханган ажиллах

3.1.7.Шаардлагатай тохиолдолд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг бүх төрлийн худалдаа, үйлчилгээний байгууллагуудын удирдах ажилтан, мэргэжилтний илтгэлийг зөвлөлийн хурлаар авч хэлэлцэх, үүрэг даалгавар өгч биелэлтийг нь гаргуулж авах.

3.1.8.Худалдаа, үйлчилгээнд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх талаар ямагт шинийг эрэлхийлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, стандартын шаардлага хангасан соёлч боловсон үйлчилгээ нэвтрүүлж дэлгэрүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулна.

3.2.Зохицуулах зөвлөлийн даргын эрх, үүрэг:

3.2.1.Зохицуулах зөвлөлийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, гишүүддээ ажил үүргийг нь хуваарилан хариуцуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, ажлынх нь үр дүнг тооцон, үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.

3.2.2.Зохицуулах зөвлөлийн дарга нь хурлаар хэлэлцэх асуудлыг баталж хурлыг удирдан явуулна.

3.2.3.Хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулж, түүний хэрэгжилтийг хангуулна.

3.2.3.Зөвлөлийн дарга шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

3.3.Зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

3.3.1.Зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралд хэлэлцэх асуудлын талаар холбогдох ажилтнуудаас материалыг бүрэн гаргуулах

3.3.2.Зохицуулах зөвлөлийн архив, бичиг хэргийг хөтлөх;

3.3.3.Хүндэтгэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа хуралд оролцоогүй гишүүний талаар санал боловсруулж, зохицуулах зөвлөлийн даргад танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.3.4Зөвлөлийн шийдвэрийг холбогдох ажилтнуудад мэдээлэх, зохион байгуулах;

3.4Зохицуулах зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг

3.4.1Зөвлөлийн хурлын албан ёсны тэмдэглэлтэй танилцаж тодруулга хийх;

3.4.2Хэлэлцэх асуудалтай холбоотой шаардлагатай баримт бичиг, мэдээллээр бүрэн хангагдах

3.4.3Хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хуралд тогтмол оролцох;

3.4.4Хуралд хүрэлцэн ирэх боломжгүй тохиолдолд нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх;

3.4.5Хурлаар хэлэлцэх асуудлын материалтай танилцах, санал, дүгнэлтийг товч, тодорхой гаргах;

3.4.6Хуралд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд саналаа бичгээр өгөх;

3.4.7Асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх явцад аль нэг талын болон хувийн ашиг сонирхлыг илэрхийлэхгүй байх;

3.4.8Холбогдох хууль, дүрэм, журамд нийцэхгүй санал гаргахгүй байх;

3.4.9Хууль тогтоомж, дүрэм, журмаар тогтоосон бусад үүргийг биелүүлж ажиллах;

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

4.1“Зөвлөл” -ийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.2“Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-д бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн бүрдүүлэх баримт бичгийг тогтоосон хугацаанд системд оруулсан эсэх, холбогдох хууль тогтоомж, стандарт, тавигдах шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт тавьж, бүртгэлийг баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд ажлын байрыг газар дээр нь очиж шалгах.

4.3Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг мэдээллийн систем ашиглан бүртгэлжүүлж, нэгдсэн санг бүрдүүлэх.

4.4Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, дүрэм журам, удирдах дээд байгууллагаас гаргасан тушаал, захирамж шийдвэрийг цаг хугацаанд нь зохион байгуулж, сурталчилж, хэрэгжилтийг ханган ажиллана.

4.5Дүүргийн нутаг дэвсгэрт сүүдрэвчтэй худалдаа, бусад гудамжны жижиглэнгийн худалдаа /жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, зайрмаг, ус ундаа/-г эрхлэх тур ажлын байрны байршил, тоо хэмжээ, унэ тарифыг тогтоож хийц, өнгө үзэмж, аюулгүй байдалд тавигдах тусгай шаардлагыг батална.

4.6Дүүргийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг, улирлын чанартай тур сүүдрэвчтэй худалдаа, үйлчилгээ болон явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийг байршлыг тогтоож, дүүргийн Засаг даргын захирамжаар батлуулах.

4.7Худалдаа үйлчилгээний чиглэлээр нутаг дэвсгэртээ тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагад уламжлах.

4.8Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг бүрэн хангасан, үлгэр жишээ тохижилт хийсэн, тохирлын баталгаатай үйлчилгээг бодлогоор дэмжих. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалтыг явуулж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулж үр дүнг тайлagnаж ажиллана.

4.9Үйл ажиллагааны явцад хяналт шалгалтаар стандартын шаардлага хангаагүй үйлчилгээ явуулсан тохиолдолд гэрээг цуцалснаар тухайн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг зогсоосонд тооцно.

4.10Зохицуулах зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийн талаар олон нийтийг мэдээллээр хангана.

4.11Энэ журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд авсан арга хэмжээний талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад хагас, бүтэн жилээр тайлagnаж, өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлэх.

4.12Зөвлөлийн шийдвэр нь “Хурлын тэмдэглэл” байх бөгөөд Зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Зөвлөлийн шийдвэрийг тухайн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заавал биелүүлнэ.

4.13Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй дүүргийн иргэн аж ахуйн нэгжийн зуны түр худалдаа, сүүдрэвчтэй худалдаа, тоглоом ажиллуулах хүсэлтийг шийдвэрлэх.

ТАВ.ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮ

5.1.Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэрэг, техник тоног төхөөрөмж, бензин шатахуун, захиргааны журмаар хураагдсан эд зүйл болон

бараа бүтээгдэхүүнийг ачих, тээвэрлэх, устгах зэрэг үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлыг дүүргийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

ЗУРГАА ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ, ХУРЛЫН ДЭГ

Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг төлөвлөх, хуралд бэлтгэн оруулах, хурлыг явуулах, баримтжуулах, хурлаас гарах шийдвэрийг гаргах зэрэг иж бүрэн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

- 6.1.Зохицуулах зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга удирдаж явуулна.
- 6.2.Зөвлөлийн даргын эзгүйд Засаг даргын Тамгын газрын дарга түүнийг орлон ажиллана.
- 6.3.Хэлтэс, албадаас зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэх асуудлыг Зөвлөлийн даргад урьдчилан танилцуулна.
- 6.4.Зохицуулах зөвлөлийн даргатай зөвшилцсөний дагуу асуудал хэлэлцүүлэх хэлтэс, албадаас хуралдааны товыг З хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд хүргэнэ.
- 6.5.Хуралд тухайн асуудал хэлэлцүүлэх хэлтэс, албадын дарга нар санал, дүгнэлтээ танилцуулна.
- 6.6.Хурлын тэмдэглэлийг тухайн асуудал хэлэлцүүлж буй хэлтэс, албад, түүний мэргэжилтнүүд нэгтгэн Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 6.7.Хэлэлцэх асуудлын онцлогийг харгалзан мэдээлэл авах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг оролцуулж болно.
- 6.8.Зохицуулах зөвлөлийн гишүүдийн 50-аас дээш хувийн ирц бүрдсэн нөхцөлд хуралдааныг хуралдуулна. Саналыг бичгээр өгсөн тохиолдолд хуралд оролцсонд тооцно.
- 6.9.Зөвлөлийн гишүүд санал зөрөлдвөл асуудлыг олонхын саналаар шийдвэрлэх бөгөөд төлөвлөгөөнд ороогүй боловч нэн яаралтай хэлэлцэх асуудал гарвал Зохицуулах зөвлөлийн даргын саналаар хэлэлцүүлж болно.
- 6.10.Зохицуулах зөвлөлийн гишүүн болон хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралд оролцох албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд зөвлөлийн хуралд заавал оролцох үүрэгтэй.
- 6.11.Ээлжит бус хурал хийхдээ энэхүү дэгийг баримтална.
- 6.12.Зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлийг ажлын З хоногт багтаан албажуулж, холбогдох шийдвэрийг гаргуулна.
- 6.13.Зохицуулах зөвлөл нь хэлэлцсэн асуудал, шийдвэрлэсэн асуудлын талаар дүүргийн Засаг даргад хагас, бутэн жилээр тайлагнаж, шаардлагатай тохиолдолд тухай бүр танилцуулан шийдвэр гаргуулж ажиллана.